



**МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

**ТАНИЛЦУУЛГА:
*ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН,
ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО
2014 ОНД***

2015 он

ГАРЧИГ

Удиртгал

ДНБ-ий 2010-2014 оны гүйцэтгэл

Нэг. Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий гүйцэтгэл

1. ДНБ-ий оны үнийн тооцоо
 - 1.1 ДНБ, салбараар
 - 1.2 Бүс, аймгийн ДНБ-ий тооцоо
2. ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоо

Хоёр. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий гүйцэтгэл

Гурав. Орлогын аргаар тооцсон ДНБ-ий гүйцэтгэл

Дөрөв. Үндэсний нийт орлого

Тав. Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

Хавсралт 1. ДНБ, оны үнээр, тэрбум төг

Хавсралт 2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг

Хавсралт 3. Макро-эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Хавсралт 4. Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

Хавсралт 5. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр, сая төг

Удиртгал

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь улс орны эдийн засгийн үйл ажиллагааны цар хэмжээг харуулдаг макро эдийн засгийн чухал үзүүлэлт юм.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог. Нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч нэмэгдэл өртгөөр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хуримтлал, цэвэр экспортын нийлбэрээр тодорхойлохыг эцсийн ашиглалтын; хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, үйлдвэрлэл болон импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого зэрэг орлогын элементийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоо нь эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хийгддэг ба эдгээр эдийн засгийн салбарын үйл ажиллагаа нь ДНБ-д ямар хувь нэмэр оруулж байгааг харуулдаг.

ДНБ-ий эцсийн ашиглалтыг эцсийн хэрэглээ (өрхийн аж ахуйн, өрхийн аж ахуйд үйлчилдэг арилжааны бус байгууллагын, төрийн байгууллагын хэрэглээ), хөрөнгийн нийт хуримтлал (үндсэн хөрөнгийн, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлс), экспорт, импортын үйл ажиллагаа гэсэн үндсэн хүрээ, холбогдох дэд хэсгүүдэд хуваагддаг.

Мөн эдийн засгийн бодит өсөлтийг үнийн өсөлтийн нөлөөллийг арилгасан буюу зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий өөрчлөлтөөр тодорхойлдог. Эдийн засгийн орчин, салбарын бүтцэд гарах өөрчлөлт нь суурь оныг тодорхой давтамжтай өөрчлөх үндэслэл болдог.

Манай улс өмнө нь ААНБ-ын тооцоонд 1967, 1986, 1993, 1995, 2000, 2005 оныг суурь он болгон ашиглаж байсан. ДНБ-ий зэрэгцүүлэх суурь оныг 2010 оноор шинэчлэхтэй холбоотой дагалдах судалгаа, тооцооллуудыг хийлээ.

ДНБ-ий суурийг шинэчлэхтэй холбогдон хийсэн тооллого, судалгаа:

- Тооллого: ААНТ, ХААТ, ХАОСТ
- Судалгаа, тооцоолол:
 - ДЭЗ-ийн бүрэн хэмжээний судалгаа, тооцоолол
 - Малын ашиг шим, гарцын судалгаа, холбогдох тооцоолол
 - Үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, үнийн индексийн тооцоолол

Үндэсний нийт орлого (ҮНО) тухайн улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн дүн байна. ҮНО-ыг ДНБ дээр гадаад эдийн засгаас орж ирсэн цэвэр орлого буюу эдийн засгийн харьяатаас орж ирсэн орлогоос харьяат бусад төлсөн зардлыг хасч тооцоолно.

Гадаад эдийн засгаас орж ирэх орлогод харьяат, харьяат бусын хооронд үйлдвэрлэлийн үйл явцад орц буюу хөдөлмөр нийлүүлэх, санхүүгийн хөрөнгө эзэмших, байгалийн баялгийг түрээслэхтэй холбогдон гарсан ажил, гүйлгээ, түүний орлогыг хамааруулна.

ҮСХ-ны даргын 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 01/134 тоот тушаалаар баталсан “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон Үндэсний нийт орлого тооцох аргачлал”-ын дагуу ДНБ-ны тооцоог жил бүр хийж хэрэглэгчдэд тархааж байна.

Танилцуулга нь ДНБ-ий үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын аргаар 2010 оны нөөц ашиглалтын хүснэгтэд тулгуурлан тооцсон үр дүнгүүд, ҮНО, ҮНЭО болон хавсралт (ДНБ-тэй холбоотой макро-эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүдийг тусгасан) гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

ДНБ-ий 2014 оны гүйцэтгэл

ДНБ-ий 2014 оны гүйцэтгэлийг үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар, оны болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр, орлогын аргаар оны үнээр тооцсон.

ДНБ, оны үнээр

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ оны үнээр 2014 онд 21975.5 тэрбум төг, эцсийн ашиглалтын аргаарх ДНБ 21897.8 тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ий 2 аргын тооцооны зөрүү 0.4 хувь байна.

Хүснэгт 1. ДНБ, оны үнээр

	2010	2011	2012	2013	2014
<i>ДНБ (тэрбум төг.)</i>					
ДНБ (үйлдвэрлэлийн)	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 975.5
ДНБ (эцсийн ашиглалтын)	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 897.8
<i>Өөрчлөлт өмнөх оныхоос (хувиар)</i>					
ДНБ (үйлдвэрлэлийн)		35.0	26.7	14.9	14.6
ДНБ (эцсийн ашиглалтын)		35.0	26.7	14.9	14.2

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2014 онд 15474.4 тэрбум төг, эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 15536.6 тэрбум төг болж, өмнөх оныхоос үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 7.8 хувь, эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 8.0 хувиар өслөө.

Хүснэгт 2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

	2010	2011	2012	2013	2014
<i>ДНБ (тэрбум төг.)</i>					
ДНБ (үйлдвэрлэлийн)	9 756.6	11 443.6	12 853.4	14 350.7	15 474.4
ДНБ (эцсийн ашиглалтын)	9 756.6	11 467.7	12 898.9	14 391.4	15 536.6
<i>Өөрчлөлт өмнөх оныхоос (хувиар)</i>					
ДНБ (үйлдвэрлэлийн)		17.3	12.3	11.6	7.8
ДНБ (эцсийн ашиглалтын)		17.5	12.5	11.6	8.0

НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААРХ ДНБ-ИЙ 2014 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

1. ДНБ-ий оны үнийн тооцоо

1.1. ДНБ, салбараар


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ оны үнээр 2014 онд 21975.5 тэрбум төгрөгт хүрч, 2013 оныхоос 2801.3 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар нэмэгдлээ.

Хүснэгт 3. ДНБ, оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	$\frac{2014}{2013}$ %
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 975.5	114.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 144.7	1 357.9	1 878.8	2 572.0	2 972.8	115.6
Уул уурхай, олборлолт	2 102.2	2 536.2	2 742.8	2 849.4	3 753.6	131.7
Боловсруулах үйлдвэрлэл	664.8	931.4	1 248.7	1 672.3	1 802.6	107.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190.2	212.4	233.9	270.5	313.2	115.8
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31.2	45.0	72.5	77.5	85.6	110.4
Барилга	250.2	402.8	837.5	979.7	1 090.0	111.3
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 199.0	1 973.3	2 231.1	2 267.2	2 423.6	106.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677.9	802.9	894.4	843.6	981.5	116.3
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.6	94.3	186.2	205.5	195.2	95.0
Мэдээлэл, холбоо	255.7	290.3	379.6	413.9	489.6	118.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	239.6	381.1	583.5	782.3	1 029.9	131.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	687.7	884.2	957.3	1 162.3	1 465.8	126.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	132.3	216.2	424.2	446.8	483.5	108.2
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	71.2	177.6	213.4	245.1	114.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	425.4	515.3	699.1	788.8	907.2	115.0
Боловсрол	379.9	503.1	745.0	854.6	976.1	114.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	167.2	193.2	317.0	359.1	412.2	114.8
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32.0	39.5	87.0	87.2	92.5	106.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.4	67.2	137.8	149.3	180.2	120.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	998.4	1 656.3	1 854.4	2 178.6	2 075.3	95.3

2014 онд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 15.6 хувь, үйлдвэрлэлийн салбарынх 20.4 хувь, үйлчилгээний салбарынх 15.3 хувиар өсч, бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 4.7 хувиар өмнөх оныхоос буурсан байна.

Зураг 1. ДНБ, салбарын бүтэц, хувиар



Үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувийн жин 2014 онд хамгийн өндөр буюу 45.0 хувь байсан байна. Энэ нь өмнөх оныхтой харьцуулахад 0.3 пунктээр өсчээ. Үйлдвэрлэлийн салбарын хувьд 2014 онд нийт ДНБ-ий гуравны нэгийг бий болгож байна. Хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь өмнөх оныхоос 0.1 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 4. ДНБ-ий салбарын бүтэц, хувиар

	2010	2011	2012	2013	2014
ДНБ	100.0	100.0	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	11.6	10.2	11.2	13.4	13.5
Уул уурхай, олборлолт	22.4	21.8	17.8	15.9	17.6
Боловсруулах үйлдвэрлэл	8.6	8.6	9.0	10.7	10.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.8	1.4	1.3	1.5	1.6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	0.4	0.4	0.5	0.4	0.4
Барилга	2.9	3.7	5.9	5.8	5.6
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	18.7	22.1	19.9	18.4	16.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	7.2	6.2	5.2	4.3	4.3
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0.6	0.8	1.2	1.2	1.0
Мэдээлэл, холбоо	3.0	2.6	2.6	2.5	2.5
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	2.5	2.9	3.5	4.1	4.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7.1	6.8	5.8	6.2	6.7
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.5	1.8	2.8	2.8	2.4
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.0	0.7	1.2	1.2	1.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	4.4	3.9	4.2	4.1	4.1
Боловсрол	3.9	3.8	4.5	4.5	4.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.7	1.5	1.9	1.9	1.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.3	0.3	0.5	0.5	0.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.5	0.5	0.8	0.8	0.8


1.2 Бүс, аймгийн ДНБ-ий гүйцэтгэл

Бүсийн ДНБ-ий (оны үнээрх) 2014 оны гүйцэтгэлийг өмнөх оныхтой харьцуулбал баруун бүсийнх 24.0 хувь, хангайн бүсийнх 14.2 хувь, төвийн бүсийнх 19.0 хувь, зүүн бүсийнх 28.5 хувь, Улаанбаатарынх 12.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. ДНБ, бүс, аймгаар, оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	$\frac{2014}{2013}$ %
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 975.5	114.6
Баруун бүс	493.7	656.4	860.4	1 136.9	1 409.7	124.0
Баян-Өлгий	108.3	143.2	179.6	232.1	291.6	125.7
Говь-Алтай	66.0	89.2	125.8	164.8	215.8	131.0
Завхан	100.2	137.2	192.3	252.6	306.5	121.3
Увс	106.1	145.1	183.0	234.6	294.3	125.4
Ховд	113.2	141.8	179.7	252.8	301.5	119.3
Хангайн бүс	1 535.2	1 902.5	2 269.0	2 701.6	3 085.2	114.2
Архангай	120.1	175.0	252.4	315.9	368.7	116.7
Баянхонгор	105.4	145.4	193.8	261.2	328.6	125.8
Булган	131.3	158.8	188.2	257.3	295.9	115.0
Орхон	882.6	1 043.8	1 138.0	1 190.4	1 267.2	106.5
Өвөрхангай	103.8	148.3	206.9	307.3	381.7	124.2
Хөвсгөл	192.1	231.1	289.7	369.5	443.1	119.9
Төвийн бүс	1 179.7	1 427.2	1 744.7	2 137.1	2 542.5	119.0
Говьсүмбэр	29.4	34.4	40.5	57.6	73.0	126.7
Дархан-Уул	163.8	192.3	258.1	305.1	367.9	120.6
Дорноговь	106.0	173.5	237.4	273.1	309.9	113.5
Дундговь	69.5	88.8	121.5	179.4	213.9	119.2
Өмнөговь	238.7	361.9	364.6	454.7	488.0	107.3
Сэлэнгэ	395.2	361.9	444.3	492.6	603.0	122.4
Төв	177.2	214.4	278.3	374.5	486.8	130.0
Зүүн бүс	394.0	545.2	688.0	945.8	1 215.1	128.5
Дорнод	139.3	208.6	247.3	383.9	554.9	144.5
Сүхбаатар	143.2	178.6	234.2	278.7	338.3	121.4
Хэнтий	111.5	158.0	206.5	283.2	321.9	113.7
Улаанбаатар	6 153.9	8 642.5	11 126.3	12 252.7	13 723.0	112.0

Зураг 2. Бүсийн ДНБ (оны үнээрх)-ий өсөлт, хувиар



ДНБ-д эзлэх хувийн жин 2014 оны гүйцэтгэлийг өмнөх оныхтой харьцуулахад баруун бүсийнх 0.5 пунктээр, төвийн бүсийнх 0.5 пунктээр, зүүн бүсийнх 0.6 пунктээр нэмэгдэж, харин Хангайн бүсийнх 0.1 пунктээр, Улаанбаатарынх 1.5 пунктээр буурсан байна.

Хүснэгт 6. ДНБ-д бүс, аймгийн эзлэх хувийн жин

	2010	2011	2012	2013	2014
ДНБ	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун бүс	5.1	5.0	5.2	5.9	6.4
Баян-Өлгий	1.1	1.1	1.1	1.2	1.3
Говь-Алтай	0.7	0.7	0.8	0.9	1.0
Завхан	1.0	1.0	1.2	1.3	1.4
Увс	1.1	1.1	1.1	1.2	1.3
Ховд	1.2	1.1	1.1	1.3	1.4
Хангайн бүс	15.7	14.4	13.6	14.1	14.0
Архангай	1.2	1.3	1.5	1.6	1.7
Баянхонгор	1.1	1.1	1.2	1.4	1.5
Булган	1.3	1.2	1.1	1.3	1.3
Орхон	9.0	7.9	6.8	6.2	5.8
Өвөрхангай	1.1	1.1	1.2	1.6	1.7
Хөвсгөл	2.0	1.8	1.7	1.9	2.0
Төвийн бүс	12.1	10.8	10.5	11.1	11.6
Говьсүмбэр	0.3	0.3	0.2	0.3	0.3
Дархан-Уул	1.7	1.5	1.5	1.6	1.7
Дорноговь	1.1	1.3	1.4	1.4	1.4
Дундговь	0.7	0.7	0.7	0.9	1.0
Өмнөговь	2.4	2.7	2.2	2.4	2.2
Сэлэнгэ	4.1	2.7	2.7	2.6	2.7
Төв	1.8	1.6	1.7	2.0	2.2
Зүүн бүс	4.0	4.1	4.1	4.9	5.5
Дорнод	1.4	1.6	1.5	2.0	2.5
Сүхбаатар	1.5	1.4	1.4	1.5	1.5
Хэнтий	1.1	1.2	1.2	1.5	1.5
Улаанбаатар	63.1	65.6	66.7	63.9	62.4

Хүснэгт 7. Салбарт эзлэх бүсийн хувийн жин, 2014

	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	Дүн
Хөдөө аж ахуй	21.0	33.6	28.2	14.1	3.1	100.0
Аж үйлдвэр, барилга	3.0	17.9	11.7	6.9	60.5	100.0
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	3.4	4.0	4.4	1.0	87.2	100.0
Тээвэр, мэдээлэл, холбоо	3.3	3.6	6.5	0.8	85.8	100.0
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	3.4	5.3	6.0	2.1	83.2	100.0
Бусад үйлчилгээ	6.9	9.1	9.6	3.9	70.5	100.0

2. ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоо

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2014 оны гүйцэтгэлээр 7.8 хувиар өсч, 15474.4 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт 8. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	$\frac{2014}{2013} \%$
ДНБ	9 756.6	11 443.6	12 853.4	14 350.7	15 474.4	107.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 144.7	1 141.1	1 381.3	1 646.2	1 871.4	113.7
Уул уурхай, олборлолт	2 102.2	2 263.7	2 452.2	2 905.8	3 460.6	119.1
Боловсруулах үйлдвэрлэл	664.8	717.1	779.7	859.7	899.0	104.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190.2	203.1	213.2	224.8	238.6	106.2
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31.2	31.9	31.5	33.3	30.7	92.1
Барилга	250.2	307.0	568.8	614.2	620.6	101.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 199.0	1 755.4	1 965.6	2 139.6	2 151.3	100.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677.9	780.0	843.2	831.0	948.2	114.1
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.6	66.7	75.8	79.6	70.9	89.2
Мэдээлэл, холбоо	255.7	270.5	314.3	361.1	387.5	107.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	239.6	357.4	509.0	666.0	883.3	132.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	687.7	704.0	718.0	742.1	769.5	103.7
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	132.3	133.8	135.3	146.0	164.1	112.4
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	82.6	84.3	87.6	88.4	100.9
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	425.4	387.5	408.0	423.6	434.3	102.5
Боловсрол	379.9	383.0	387.3	392.4	398.6	101.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	167.2	151.6	154.9	166.6	182.3	109.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32.0	28.3	28.9	30.3	30.4	100.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.4	52.4	57.6	62.0	63.1	101.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	998.4	1 626.5	1 744.4	1 938.8	1 781.7	91.9

ДНБ өмнөх оныхоос 7.8 хувь өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 225.2 тэрбум төг буюу 13.7 хувь, уул уурхай, олборлох салбар 554.7 тэрбум төг буюу 19.1 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 39.3 тэрбум төг буюу 4.6 хувь, барилгын салбар 6.4 тэрбум төг буюу 1.0 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбар 11.7 тэрбум төг буюу 0.5 хувь, санхүү, даатгалын салбар 217.2 тэрбум төг буюу 32.6 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.

ХОЁР. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААР ТООЦСОН ДНБ-ИЙ ГҮЙЦЭТГЭЛ


2.1 ДНБ-ий оны үнийн тооцоо

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 2014 оны гүйцэтгэлээр, оны үнээр 21897.8 тэрбум төг болж, өмнөх оныхоос 2723.6 тэрбум төг буюу 14.2 хувиар өслөө.

Хүснэгт 9. ДНБ, оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	<u>2013%</u> <u>2012</u>	<u>2014%</u> <u>2013</u>
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 897.8	114.9	114.2
Эцсийн хэрэглээ	6 625.2	8 397.1	11 105.4	13 279.3	15 542.1	119.6	117.0
Хөрөнгийн нийт хуримтлал	4 106.3	7 660.6	9 328.6	10 215.2	7 298.6	109.5	71.4
Цэвэр экспорт	- 974.9	- 2 884.0	- 3 745.6	- 4 320.2	- 943.0	-	-

Зураг 3. ДНБ, оны үнээр, тэрбум төг



Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 14.2 хувиар өсөхөд эцсийн хэрэглээ 2262.8 тэрбум төг буюу 17.0 хувиар өсч, цэвэр экспортын алдагдал 3377.2 тэрбум төг буюу 78.2 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий 2014 оны бүтцийг авч үзвэл эцсийн хэрэглээ 71.0 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 33.3 хувь, цэвэр экспорт -4.3 хувь болж, өмнөх оныхоос эцсийн хэрэглээ 1.8 пункт, цэвэр экспорт 18.2 пунктээр тус тус өсч, хөрөнгийн нийт хуримтлал 20.0 пунктээр буурсан байна.

Хүснэгт 10. Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий бүтэц, оны үнээр, хувиар

	2010	2011	2012	2013	2014
ДНБ	100.0	100.0	100.0	100.0	100.0
Эцсийн хэрэглээ	67.9	63.7	66.5	69.2	71.0
өрхийн аж ахуйн хэрэглээ	54.6	50.9	52.5	55.4	57.3
төрийн байгууллагын хэрэглээ	12.7	12.3	13.5	13.5	13.2
төрийн бус байгууллагын хэрэглээ	0.6	0.6	0.5	0.4	0.5
Хөрөнгийн нийт хуримтлал	42.1	58.2	55.9	53.3	33.3
үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	34.5	48.4	45.1	39.3	25.4
материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт болон үнэт зүйлсийн	7.6	9.7	10.8	14.0	7.9


хуримтлал

Цэвэр экспорт	- 10.0	- 21.9	- 22.4	- 22.5	- 4.3
бараа, үйлчилгээний экспорт	46.7	52.6	43.6	38.9	53.2
бараа, үйлчилгээний импорт	56.7	74.4	66.0	61.4	57.5

Эцсийн хэрэглээ


Эцсийн хэрэглээ 2014 онд 15542.1 тэрбум төг болж, өмнөх оныхоос 2262.8 тэрбум төг буюу 17.0 хувиар өслөө. Эцсийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувийн жин 2014 онд 71.0 хувь болж өмнөх оныхоос 1.8 пунктээр өссөн байна.

Зураг 4. ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтэц, оны үнээр, хувиар




Өрхийн хэрэглээ 2012 онд 30.7 хувь, 2013 онд 21.1 хувь, 2014 онд 18.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг 5. Өрхийн хүнсний болон хүнсний бус хэрэглээ, тэрбум төг



Зураг 6. Өрхийн эцсийн хэрэглээний өсөлт, хувиар



Өрхийн хэрэглээний нийт зардал дотор өрхийн хүнсний хэрэглээний зардал 15.8 хувиар, хүнсний бус хэрэглээний зардал 19.8 хувиар тус тус өссөн байна.

Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ 2014 оны гүйцэтгэлээр 2893.3 тэрбум төг болж, өмнөх оныхоос 313.0 тэрбум төг буюу 12.1 хувиар өссөн байна.

Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ 2014 оны гүйцэтгэлээр 104.7 тэрбум төг болж, өмнөх оныхоос 19.2 тэрбум төг буюу 22.4 хувиар нэмэгдлээ.

Хөрөнгийн нийт хуримтлал

Хүснэгт 11. Хөрөнгийн нийт хуримтлал, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	<u>2013%</u> 2012	<u>2014%</u> 2013
Хөрөнгийн нийт хуримтлал	4 106.3	7 660.6	9 328.6	10 215.2	7 298.6	109.5	71.4
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	3 364.7	6 377.7	7 529.2	7 528.5	5 568.0	100.0	74.0
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт болон үнэт зүйлсийн хуримтлал	741.6	1 282.9	1 799.4	2 686.7	1 730.7	149.3	64.4

Үндсэн хөрөнгийн хуримтлалын хэмжээ 2014 оны гүйцэтгэлээр 5568.0 тэрбум төг болж, өмнөх оныхоос 1960.5 тэрбум төг буюу 26.0 хувиар буурсан байна.

Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт болон үнэт зүйлсийн хуримтлал 2014 оны гүйцэтгэлээр 1730.7 тэрбум төг болж, өмнөх оныхоос 956.0 тэрбум төг буюу 35.6 хувиар буурчээ.

Цэвэр экспорт

Барааны экспорт 2014 оны гүйцэтгэлээр 5774.3 сая ам.долл, импорт 5236.7 сая ам.долл болж, өмнөх оныхоос экспорт 1505.2 сая ам.долл буюу 35.3 хувиар өсч, импорт 1121.1 сая ам.долл буюу 17.6 хувиар буурсан.

ДНБ-ийг үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцдог учир цэвэр экспортын хэмжээг төгрөг рүү шилжүүлэн тооцоход бараа, үйлчилгээний экспорт 11647.8 тэрбум төг, импорт 12590.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос экспорт 56.2 хувь, импорт 6.9 хувиар өссөн дүнтэй гарлаа. Энэ нь америк долларын төгрөгтэй харьцах ханшийн өсөлттэй холбоотой юм.

Цэвэр экспорт буюу гадаад худалдааны алдагдал 2014 онд 943.0 тэрбум төг болж, өмнөх оныхоос алдагдал 3377.2 тэрбум төг буюу 78.2 хувиар буурчээ.

Хүснэгт 12. Экспорт, импортын хэмжээ, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	<u>2013%</u> 2012	<u>2014%</u> 2013
Цэвэр экспорт	- 974.9	- 2 884.0	- 3 745.6	- 4 320.2	- 943.0	115.3	21.8
Экспорт	4 554.3	6 923.3	7 271.5	7 456.9	11 647.8	102.5	156.2
бараа	3 932.0	6 150.5	6 014.4	6 376.9	10 567.6	106.0	165.7
үйлчилгээ	622.3	772.8	1 257.1	1 080.0	1 080.2	85.9	100.0
Импорт	5 529.2	9 807.3	11 017.1	11 777.2	12 590.8	106.9	106.9
бараа	4 702.6	8 587.0	9 387.3	9 801.0	9 528.8	104.4	97.2
үйлчилгээ	826.6	1 220.3	1 629.8	1 976.2	3 062.0	121.2	154.9

2.2 ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоо


Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 2014 оны гүйцэтгэлээр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 15536.6 тэрбум төг болж, өмнөх оноос 1145.2 тэрбум төг буюу 8.0 хувиар өслөө.

Хүснэгт 13. ДНБ, зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	<u>2013%</u> <u>2012</u>	<u>2014%</u> <u>2013</u>
ДНБ	9 756.6	11 467.7	12 898.9	14 391.4	15 536.6	111.6	108.0
Эцсийн хэрэглээ	6 625.2	7 667.7	8 762.7	10 121.6	10 990.2	115.5	108.6
Хөрөнгийн нийт хуримтлал	4 106.3	6 683.4	7 847.8	7 953.8	5 346.4	101.4	67.2
Цэвэр экспорт	- 974.9	- 2 883.4	- 3 711.6	- 3 684.1	- 799.9	-	-

Эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ 8.0 хувиар өсөхөд эцсийн хэрэглээ 868.6 тэрбум төг буюу 8.6 хувиар өсч, цэвэр экспортын алдагдал 2884.2 тэрбум төгрөг буюу 78.3 хувиар буурсан нь нөлөөллөө.

Зураг 7. ДНБ-ий бодит өсөлтөд бүрэлдэхүүн хэсгийн оролцоо



Эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий 8.0 хувийн өсөлтийн 6.0 пунктийг эцсийн хэрэглээ (-18.0) пунктийг хөрөнгийн нийт хуримтлал, 20.0 пунктийг цэвэр экспорт бүрдүүлжээ.

ГУРАВ. ОРЛОГЫН АРГААР ТООЦСОН ДНБ-ИЙ ГҮЙЦЭТГЭЛ

ДНБ-ий орлогын арга анхдагч орлогуудын нийлбэр буюу бараа, үйлчилгээний дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнээс бий болсон ашиг болон орлогоос бүрдэнэ.

Орлогын аргаар тооцсон ДНБ оны үнээр 2014 онд 21975.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос цалин, түүнтэй адилтгах орлогын хэмжээ 17.3 хувь, цэвэр ашиг, холимог орлого 14.0 хувь, үндсэн хөрөнгийн хэрэглээ 41.5 хувиар нэмэгдэж, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 14. ДНБ, орлогын бүрэлдэхүүн хэсгээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	<u>2014%</u> 2013
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 975.5	114.6
Цалин, түүнтэй адилтгах орлого	2 198.2	3 150.1	4 393.9	4 979.9	5 839.4	117.3
Үйлдвэрлэл, импортын цэвэр татвар	1 040.4	1 688.8	1 880.6	2 250.1	2 189.6	97.3
Ашиг/холимог орлого, цэвэр	6 518.0	8 334.9	10 413.9	11 944.2	13 946.5	116.8
ДНБ	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Цалин, түүнтэй адилтгах орлого	22.5	23.9	26.3	26.0	26.6	
Үйлдвэрлэл, импортын цэвэр татвар	10.7	12.8	11.3	11.7	10.0	
Ашиг/холимог орлого, цэвэр	66.8	63.3	62.4	62.3	63.4	

Ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого нь ДНБ-ий орлогын 2 дахь том бүрэлдэхүүн бөгөөд 2014 оны гүйцэтгэлээр ДНБ-ий 26.6 хувийг эзэлж байна.

Үйл ажиллагааны ашиг, холимог орлого ДНБ-ий орлогын томоохон бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2014 оны гүйцэтгэлээр ДНБ-д 63.4 хувийг эзэлж байна.

Зураг 8. Ажиллагчдын цалин, ашиг, холимог орлогын ДНБ-д эзлэх хувь



ДӨРӨВ. ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО, ҮНДЭСНИЙ ЭЗЭМШЛИЙН ОРЛОГО

Үндэсний нийт орлого (ҮНО) гэдэг нь тухайн улсын эдийн засгийн харьяатуудын шинээр бий болгосон нэмэгдсэн өртөг юм. ҮНО-ыг тооцохдоо эдийн засгийн харьяатын зарчимд тулгуурлах буюу ДНБ-ий гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн дараах 2 төрлийн ажил гүйлгээний цэвэр орлогын хэмжээг нэмнэ. Үүнд, а. харьяат бус ажиллагчдад төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, б. хөрөнгө оруулалтын орлого буюу харьяат, харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хүүгийн орлого орно.

Үндэсний нийт эзэмшлийн орлого (ҮНЭО) нь харьяатын зарцуулах, хадгалах боломжтой орлого юм. ҮНЭО-ыг тооцохдоо ҮНО-ын гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн цэвэр шилжүүлгийг нэмж тооцно.


ҮНО 2014 оны гүйцэтгэлээр оны үнээр 20168.5 тэрбум төгрөгт хүрч, 2013 оныхоос 11.5 хувиар өслөө. ҮНО ДНБ-ий гүйцэтгэлээс 1807.0 тэрбум төгрөгөөр бага дүнтэй байна.

Хүснэгт 15. ДНБ, ҮНО, ҮНЭО оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014	$\frac{2014}{2013}$ %
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 975.5	114.6
Гадаад эдийн засгаас орж ирсэн цэвэр орлого	- 812.0	-1 067.2	-1 288.8	-1 082.9	-1 807.0	166.9
Ажиллагчдын цалин, цэвэр	- 43.7	- 146.0	- 331.0	- 285.2	-206.1	72.6
хүлээн авсан цалин (+)	24.8	38.1	46.4	69.9	97.6	139.5
төлсөн цалин (-)	68.6	184.1	377.4	355.1	303.7	85.5
Хөрөнгө оруулалтын орлого, цэвэр	- 768.3	- 921.2	- 957.9	- 797.7	-1 600.9	200.7
хөрөнгө оруулалтын орлого (+)	14.4	17.2	31.3	9.1	6.0	65.9
хөрөнгө оруулалтын зардал (-)	782.7	938.4	989.2	806.8	1 606.9	199.2
ҮНО	8 944.6	12 106.5	15 399.6	18 091.3	20 168.5	111.5
Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр шилжүүлэг	253.6	301.4	325.4	218.0	258.0	118.3
Засгийн газрын шилжүүлэг, цэвэр	44.6	22.4	49.7	45.3	51.1	112.8
хүлээн авсан шилжүүлэг (+)	47.5	35.9	55.6	52.3	58.4	111.7
шилжүүлсэн шилжүүлэг (-)	2.9	13.5	5.9	7.0	7.3	104.3
Ажиллагчдын гуйвуулга, цэвэр	175.4	74.0	55.7	36.2	55.3	152.8
хүлээн авсан гуйвуулга (+)	336.2	315.5	389.1	320.2	366.0	114.3
шилжүүлсэн гуйвуулга (-)	160.7	241.5	333.4	284.0	310.7	109.4
Торгуулийн орлого	33.5	204.9	220.1	136.5	151.6	111.1
хүлээн авсан орлого (+)	35.8	221.1	237.5	151.9	169.5	111.6
шилжүүлсэн орлого (-)	2.4	16.2	17.4	15.4	17.9	116.2
ҮНЭО	9 198.2	12 407.9	15 725.0	18 309.3	20 426.5	111.6

Үндэсний нийт эзэмшлийн орлого нь 2014 оны гүйцэтгэлээр, оны үнээр 20426.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 11.6 хувиар өссөн байна.

Зураг 9. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр, тэрбум төг




ТАВ. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, ҮНО

5.1 Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО-ын үзүүлэлтүүд

Нэг хүнд ногдох ДНБ 2014 онд оны үнээр 7403.4 мян.төг, ҮНО 6894.8 мян.төгрөгт хүрч, өмнөх оныхоос нэг хүнд ногдох ДНБ 11.9 хувь, ҮНО 10.5 хувиар нэмэгдлээ. Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2014 онд оны үнээр 4523 ам.доллар болж, 2013 оныхоос 40 ам.доллар буюу 0.9 хувиар буурч, нэг хүнд ногдох ҮНО оны үнээр 140 ам.доллар буюу 3.3 хувиар өсч, 4166 ам.долларт хүрлээ (Хавсралт 4).

Зураг 10. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, мян.төг



Нэг хүнд ногдох ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 5219.1 мян.төгрөгт хүрч, 2013 оныхоос 5.4 хувиар нэмэгдсэн байна.

5.2 Нэг хүнд ногдох ҮНО, олон улстай харьцуулсан байдал

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшинг хооронд нь харьцуулах стандарт үзүүлэлт бол нэг хүнд ногдох ҮНО юм.

Хүснэгт 16. Нэг хүнд ногдох ҮНО, бүс, улс орноор (Дэлхийн банкны атласын аргаар, оны үнээр, ам.доллар)

Улс болон бүс	2010	2011	2012	2013	2014	2014% 2013
Дэлхий	9 382	9 845	10 427	10 792	10 858	100.6
Бага орлоготой	498	525	562	599	635	106.0
Дунд орлоготой	3 335	3 709	4 195	4 528	4 690	103.6
- дунджаас доогуур орлоготой	1 595	1 759	1 969	2 068	2 343	113.3
- дунджаас дээгүүр орлоготой	5 457	6 103	6 943	7 578	7 893	104.2
Бага болон дунд орлоготой	3 116	3 449	3 857	4 131	4 263	103.2
- Зүүн Ази, Номхон далайн орнууд	3 744	4 307	5 034	5 680	6 122	107.8
- Европ, Төв Азийн орнууд	5 816	6 107	6 465	6 859	6 864	100.1
- Латин америк, Карибийн орнууд	7 473	8 201	9 029	9 290	9 051	97.4
- Өмнөд Азийн орнууд	1 206	1 339	1 435	1 478	1 527	103.3
- Саб Сахарийн орнууд	1 273	1 391	1 606	1 683	1 720	102.2
Өндөр орлоготой орнууд	34 985	36 183	37 626	38 477	38 392	99.8
- Евро бүсийн орнууд	39 744	40 052	39 251	39 317	39 174	99.6
Монгол*	2 265	2 786	3 635	4 306	4 166	96.7
ОХУ	9 980	10 820	12 730	13 810	13 210	95.7
БНХАУ	4 300	5 000	5 870	6 740	7 380	109.5

Эх сурвалж: www.worldbank.org, 2014 оны тооцоо

*ҮСХ-ны тооцоо

Дэлхийн банкнаас гаргадаг энэхүү үзүүлэлтэд манай улсыг дунд орлоготой орны дунджаас доогуур орлоготой бүлэгт хамааруулан авч үзсэн байна. Энэ бүлэг дэх орнуудын нэг хүнд ногдох ҮНО-ын дундаж 2014 оны байдлаар 2343 ам.доллар байгаа бол манай улсын нэг хүнд ногдох ҮНО 4166 ам.доллар байна. Хөрш орнуудтай харьцуулахад нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээгээр ОХУ-аас 3.2 дахин, БНХАУ-аас 1.8 дахин бага байна. Дэлхийн өсөлт 0.6 хувь, дунд орлоготой орнуудынх 3.6 хувь, БНХАУ-ынх 9.5 хувь, Зүүн Ази, Номхон далайн орнуудынх 7.8 хувь байна.

АХБ-наас гаргадаг “Asian Development Outlook” судалгааны тайланд манай орны эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь уул уурхайтай холбоотой хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэл бөгөөд цаашид уул уурхайтай холбоотой барилга болон үйлчилгээний үйл ажиллагаанд өндөр өсөлт гарна гэж дүгнэсэн байна. Тус байгууллага манай орны эдийн засгийн өсөлт 2014 онд 9.5 хувь өсөхөөр тооцоолсон байна.

Дүгнэлт

2010 оны гүйцэтгэлд суурилж байгуулсан нөөц ашиглалтын хүснэгтийн үр дүнгээр тодотгож тооцоолсон ДНБ-ий бодит хэмжээ 2013 онд 11.6 хувийн өсөлттэй гарч байсан бол 2014 онд 7.8 хувийн өсөлттэй гарлаа.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ оны үнээр 2014 онд 21975.5 тэрбум төгрөгт хүрч, 2013 оныхоос 2801.3 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар нэмэгдлээ.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр өмнөх оныхоос 7.8 хувиар өсч, 15474.4 тэрбум төгрөгт хүрлээ. ДНБ-ий бодит өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 225.2 тэрбум төг буюу 13.7 хувь, уул уурхай, олборлох салбар 554.7 тэрбум төг буюу 19.1 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 39.3 тэрбум төг буюу 4.6 хувь, барилгын салбар 6.4 тэрбум төг буюу 1.0 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбар 11.7 тэрбум төг буюу 0.5 хувь, санхүү, даатгалын салбар 217.2 тэрбум төг буюу 32.6 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ оны үнээр 2014 онд 21897.8 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 2723.5 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар өслөө.

Нэг хүнд ногдох ДНБ 2014 онд оны үнээр 7403.4 мянган төгрөгт хүрч, өмнөх оныхоос 11.9 хувиар нэмэгджээ. Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 4523 ам.доллар болж, өмнөх оныхоос 40 ам.доллар буюу 0.9 хувиар буурсан байна.

Хавсралт1. ДНБ, оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014
ДНБ	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 975.5
Өөрчлөлт, *%		35.0	26.7	14.9	14.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 144.7	1 357.9	1 878.8	2 572.0	2 972.8
Өөрчлөлт, %		18.6	38.4	36.9	15.6
Уул уурхай, олборлолт	2 102.2	2 536.2	2 742.8	2 849.4	3 753.6
Өөрчлөлт, %		20.6	8.1	3.9	31.7
Боловсруулах үйлдвэрлэл	664.8	931.4	1248.7	1 672.3	1 802.6
Өөрчлөлт, %		40.1	34.1	33.9	7.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190.2	212.4	233.9	270.5	313.2
Өөрчлөлт, %		11.7	10.1	15.7	15.8
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31.2	45.0	72.5	77.5	85.6
Өөрчлөлт, %		44.2	61.1	6.9	10.4
Барилга	250.2	402.8	837.5	979.7	1 090.0
Өөрчлөлт, %		61.0	107.9	17.0	11.3
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 199.0	1 973.3	2 231.1	2 267.2	2 423.6
Өөрчлөлт, %		64.6	13.1	1.6	6.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677.9	802.9	894.4	843.6	981.5
2Өөрчлөлт, %		18.4	11.4	-5.7	16.3
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.6	94.3	186.2	205.5	195.2
Өөрчлөлт, %		79.3	97.5	10.4	-5.0
Мэдээлэл, холбоо	255.7	290.3	379.6	413.9	489.6
Өөрчлөлт, %		13.5	30.8	9.1	18.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	239.6	381.1	583.5	782.3	1 029.9
Өөрчлөлт, %		59.1	53.1	34.1	31.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	687.7	884.2	957.3	1 162.3	1 465.8
Өөрчлөлт, %		28.6	8.3	21.4	26.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	132.3	216.2	424.2	446.8	483.5
Өөрчлөлт, %		63.4	96.2	5.3	8.2
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	71.2	177.6	213.4	245.1
Өөрчлөлт, %		-12.2	149.4	20.2	14.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	425.4	515.3	699.1	788.8	907.2
Өөрчлөлт, %		21.1	35.7	12.8	15.0
Боловсрол	379.9	503.1	745.0	854.6	976.1
Өөрчлөлт, %		32.4	48.1	14.7	14.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	167.2	193.2	317.0	359.1	412.2
Өөрчлөлт, %		15.6	64.0	13.3	14.8
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32.0	39.5	87.0	87.2	92.5
Өөрчлөлт, %		23.4	120.3	0.2	6.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.4	67.2	137.8	149.3	180.2
Өөрчлөлт, %		51.4	105.1	8.4	20.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	998.4	1 656.3	1 854.4	2 178.6	2 075.3
Өөрчлөлт, %		65.9	12.0	17.5	-4.7

*жилийн өөрчлөлт, өмнөх оны мөн үе=100, %

Хавсралт2. ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2014
ДНБ	9 756.6	11 443.6	12 853.4	14 350.7	15 474.4
Өөрчлөлт, %		17.3	12.3	11.6	7.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1 144.7	1 141.1	1 381.3	1 646.2	1 871.4
Өөрчлөлт, %		-0.3	21.0	19.2	13.7
Уул уурхай, олборлолт	2 102.2	2 263.7	2 452.2	2 905.8	3 460.6
Өөрчлөлт, %		7.7	8.3	18.5	19.1
Боловсруулах үйлдвэрлэл	664.8	717.1	779.7	859.7	899.0
Өөрчлөлт, %		7.9	8.7	10.3	4.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190.2	203.1	213.2	224.8	238.6
Өөрчлөлт, %		6.8	5.0	5.4	6.2
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31.2	31.9	31.5	33.3	30.7
Өөрчлөлт, %		2.2	-1.3	5.6	-7.9
Барилга	250.2	307.0	568.8	614.2	620.6
Өөрчлөлт, %		22.7	85.3	8.0	1.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 199.0	1 755.4	1 965.6	2 139.6	2 151.3
Өөрчлөлт, %		46.4	12.0	8.9	0.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677.9	780.0	843.2	831.0	948.2
Өөрчлөлт, %		15.0	8.1	-1.4	14.1
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.6	66.7	75.8	79.6	70.9
Өөрчлөлт, %		26.8	13.6	5.0	-10.8
Мэдээлэл, холбоо	255.7	270.5	314.3	361.1	387.5
Өөрчлөлт, %		5.8	16.2	14.9	7.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	239.6	357.4	509.0	666.0	883.3
Өөрчлөлт, %		49.2	42.4	30.8	32.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	687.7	704.0	718.0	742.1	769.5
Өөрчлөлт, %		2.4	2.0	3.4	3.7
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	132.3	133.8	135.3	146.0	164.1
Өөрчлөлт, %		1.1	1.1	7.9	12.4
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	81.1	82.6	84.3	87.6	88.4
Өөрчлөлт, %		1.8	2.1	3.9	0.9
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	425.4	387.5	408.0	423.6	434.3
Өөрчлөлт, %		-8.9	5.3	3.8	2.5
Боловсрол	379.9	383.0	387.3	392.4	398.6
Өөрчлөлт, %		0.8	1.1	1.3	1.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	167.2	151.6	154.9	166.6	182.3
Өөрчлөлт, %		-9.3	2.2	7.6	9.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32.0	28.3	28.9	30.3	30.4
Өөрчлөлт, %		-11.6	2.1	4.8	0.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	44.4	52.4	57.6	62.0	63.1
Өөрчлөлт, %		18.0	9.9	7.8	1.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	998.4	1 626.5	1 744.4	1 938.8	1 781.7
Өөрчлөлт, %		62.9	7.2	11.1	-8.1

Хавсралт 3. Макро-эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2014
А. Бодит сектор					
ДНБ(Ү),оны үнээр, тэрбум төг	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 975.5
ДНБ(Э),оны үнээр, тэрбум төг	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 897.8
ДНБ(Ү)-ий бодит өсөлт		17.3	26.7	14.9	14.6
ДНБ(Э)-ий бодит өсөлт		17.5	26.7	14.9	14.2
Хөрөнгө оруулалт (ДНБ*-д эзлэх хувь)	39.4	63.7	56.3	34.3	25.2
Гадаадын хөрөнгө оруулалт (ДНБ*-д эзлэх хувь)	25.0	45.3	38.7	19.0	6.6
Б. Санхүүгийн сектор					
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого / ДНБ	32.0	32.1	29.1	31.0	28.3
Төсвийн нийт зарлага / ДНБ	31.6	37.9	35.9	32.2	32.0
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл / ДНБ	0.4	-5.8	-6.8	-1.2	-3.7
Татварын орлого / ДНБ	27.6	27.8	25.0	26.5	23.7
Урсгал зардал / ДНБ	23.1	24.6	26.4	23.7	23.8
Хөрөнгийн зардал / ДНБ	6.1	9.7	9.1	7.8	7.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл /ДНБ	2.4	3.6	0.4	0.6	0.3
В. Мөнгөний сектор					
M2 /ДНБ	48.0	48.7	45.6	49.3	48.4
Ам.долларын жилийн дундаж ханш (1 ам.доллар = төг)	1 356.4	1 265.5	1 359.2	1 523.9	1 817.9
Г. Гадаад сектор					
Экспорт, бодит өсөлт		18.2	8.3	12.8	53.4
Импорт, бодит өсөлт		49.5	15.4	7.6	6.1
Экспорт (ДНБ*-д эзлэх хувь)	46.7	52.6	43.6	38.9	53.2
Импорт (ДНБ*-д эзлэх хувь)	56.7	74.4	66.0	61.4	57.5
Цэвэр экспорт (ДНБ*-д эзлэх хувь)	-10.0	-21.9	-22.4	-22.5	-4.3
Д. Үнэ					
Инфляцийн жилийн дундаж түвшин	10.1	9.2	14.3	10.5	12.8
ДНБ*-ий дефлятор	100.0	115.1	129.8	133.6	142.0
ДНБ*-ий дефляторын өсөлт		15.1	12.8	2.9	6.3
Е. Ажиллагчид					
Хүн ам (жилийн дундаж), мян.хүн	2 738.6	2 786.3	2 839.7	2 899.0	2 963.1
Ажиллагчид, оны эцэст	1 033.7	1 037.7	1 056.4	1 103.6	1 110.7

*ДНБ эцсийн ашиглалтын аргаар

Хавсралт 4. Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

Нэг хүнд ногдох ДНБ, ҮНО

	2010	2011	2012	2013	2014	$\frac{2014}{2013}$ %
ДНБ, оны үнээр, мян.төг	3 562.6	4 728.0	5 876.8	6 614.1	7 403.4	111.9
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг	3 562.6	4 107.1	4 526.3	4 950.2	5 219.1	105.4
ДНБ, оны үнээр, ам.доллар	2 471	3 031	3 939	4 563	4 523	99.1
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, ам.доллар	2 471	2 639	3 045	3 425	3 209	93.7
ҮНО, оны үнээр, мян.төг	3 266.1	4 345.0	5 422.9	6 240.5	6 894.8	110.5
ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг	3 266.1	3 774.3	4 176.8	4 670.6	4 860.5	104.1
ҮНО, оны үнээр, ам.доллар	2 265	2 786	3 635	4 306	4 166	96.7
ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, ам.доллар	2 265	2 420	2 800	3 223	2 934	91.0

Хавсралт 5. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр, сая төг

	2010	2011	2012	2013	2014
Дотоодын нийт бүтээгдэхүүн	9 756.6	13 173.8	16 688.4	19 174.2	21 975.5
Гадаад эдийн засгаас хүлээн авсан анхдагч орлого	39.2	55.3	77.7	79.1	103.6
Ажиллагчдын цалин	24.8	38.1	69.9	97.6	97.6
Зээлийн хүү	14.4	17.2	9.1	6.0	6.0
Гадаад эдийн засагт төлсөн анхдагч орлого	851.2	1 122.6	1 366.6	1 162.0	1 910.6
Ажиллагчдын цалин	68.6	184.1	355.1	303.7	303.7
Зээлийн хүү	782.7	938.4	806.8	1 606.9	1 606.9
Үндэсний нийт орлого	8 944.6	12 106.5	15 399.6	18 091.3	20 168.5
өөрчлөлт, %		35.4	27.2	17.5	11.5
Гадаад эдийн засгаас хүлээн авсан шилжүүлэг	419.5	572.5	682.1	524.4	593.9
Засгийн газрын шилжүүлэг	47.5	35.9	52.3	58.4	58.4
Ажиллагчдын гуйвуулга	336.2	315.5	320.2	366.0	366.0
Бусад шилжүүлэг	35.8	221.1	151.9	169.5	169.5
Гадаад эдийн засагт шилжүүлсэн шилжүүлэг	166.0	271.1	356.7	306.5	335.9
Засгийн газрын шилжүүлэг	2.9	13.5	7.0	7.3	7.3
Ажиллагчдын гуйвуулга	160.7	241.5	284.0	310.7	310.7
Бусад шилжүүлэг	2.4	16.2	15.4	17.9	17.9
Үндэсний нийт эзэмшлийн орлого	9 198.2	12 407.9	15 725.0	18 309.3	20 426.5
өөрчлөлт, %		34.9	26.7	16.1	11.6
ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	8 944.6	10 516.5	11 860.7	13 537.3	14 202.0
өөрчлөлт, %		17.6	12.8	14.1	4.9

